

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ОРШИЛ	3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
2.1. Төслийн нэр.....	4
2.2. Төсөл хэрэгжүүлэгч.....	4
2.3. Төслийн байршил	4
2.4. Ордын нөөц	6
2.5. Хүчин чадал	6
2.6.Хөрсний овоолго.....	7
2.7. Нүүрсний овоолго.....	7
2.8.Технологийн сонголт.....	7
2.9.Шимт хөрс хуулалтын төлөвлөлт	7
2.10.Техник, тоног төхөөрөмж	8
2.11.Усан хангамжийн эх үүсвэр.....	8
2.12. Ил уурхайн хэмжээс, процесс	9
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	10
БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	12
БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	13
БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	18
6.2. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил.....	18
6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.....	19
6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	21
6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	23
6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	26
6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө.....	28
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	29
ДҮГНЭЛТ.....	30
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол	4
Хүснэгт 3. Нөөцийн нэгдсэн хүснэгт	6
Хүснэгт 4. Хүчин чадал.....	6

Хүснэгт 5. Ил уурхайн технологи.....	7
Хүснэгт 6. Ашиглалтын жилд уурхайгаас хуулах шимт хөрсний хэмжээ.....	8
Хүснэгт 7. Төслийн нийт усны хэрэглээ	9
Хүснэгт 8. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	12
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
Хүснэгт 10. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийнхүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө.....	18
Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	21
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	23
Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	26
Хүснэгт 16. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө	28
Хүснэгт 17. 2026 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Уулбаян” нэртэй нүүрсний ордын байршлын зураг	5
---	---

БҮЛЭГ 1. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд энэхүү уурхайн талаарх мэдээлэл, төслийн хэрэгжилтийн явц, ашиглаж байгаа техник технологи, төсөл хэрэгжиж байгаа орчин, байгаль орчны төлөв байдал, төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаарх товч тодорхойлолт, баримтлах хууль тогтоомж, стандартын шаардлага болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тодорхой тусгасан.

БОМТ-ний тайлан боловсруулах аргачлал:

Тус төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Рич майнинг” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг **11 дүгээр сарын 01-ний** дотор энэхүү журмын 2-р хавсралтын дагуу гаргаж, төсөл хэрэгжүүлж байгаа Дорноговь аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан аймаг, нийслэлийн Байгаль орчны газар түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулж, ажилуулан дүгнэлтийг **12 дугаар сарын 1-ний** дотор гаргуулах ба уг ажлын хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын төлөөлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал орно.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Рич майнинг” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		9011202137
3	Уурхайн нэр		“Уулбаян” нэртэй нүүрсний орд ашиглах төсөл
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Дорноговь аймаг
5		Сум/Дүүрэг	Мандах
6	Ашигт малтмалын төрөл		Нүүрс
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-022815
8	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар хот
9		Сум/Дүүрэг	Хан-Уул
10		Баг/Хороо	Стадион оргил, их монгол улс, 61, Суруга центр 401
11	Захирлын хаяг	Нэр	Б.Билэгсайхан
12		Гар утас	976-99116588

2.1. Төслийн нэр

“Уулбаян” нэртэй нүүрсний орд ашиглах төсөл

2.2. Төсөл хэрэгжүүлэгч

“Рич майнинг” ХХК

2.3. Төслийн байршил


Дорноговь аймгийн Хөвсгөл, Мандах, Хатанбулаг сумдын нутагт харьяалагдах бөгөөд Уулбаянгийн чулуун нүүрсний орд нь бүхэлдээ Мандах сумын нутагт оршино. Орд нь Улаанбаатар хотоос 685км, Дорноговь аймгийн төвөөс баруун урд зүгт 221км, Хангийн хилийн боомтоос 160км, Сор говь, Айлбаянгийн ордуудын баруун урд үргэлжлэл дээр хил залган оршдог.

Зүүнбаян Хангийн чиглэлийн төмөр зам ордоос зүүн зүгт 32 км зайтай дайран өнгөрдөг.

Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	108	53	0	43	42	51.49
2	108	53	0	43	42	15
3	108	53	9.22	43	42	15
4	108	53	9.22	43	41	40.51
5	108	52	56	43	41	40.51
6	108	52	56	43	41	27.9
7	108	52	44.88	43	41	27.9
8	108	52	44.88	43	41	14.8
9	108	52	33.17	43	41	14.8

10	108	52	33.17	43	41	1.16
11	108	52	21.15	43	41	1.16
12	108	52	21.15	43	40	49.14
13	108	52	11.23	43	40	49.14
14	108	52	11.23	43	40	38.79
15	108	49	33.51	43	40	38.79
16	108	49	33.51	43	39	33.73
17	108	47	1.65	43	39	33.73
18	108	47	1.65	43	41	1.49
19	108	49	1.65	43	41	1.49
20	108	49	1.66	43	42	1.49
21	108	52	1.66	43	42	1.49
22	108	52	1.66	43	42	51.49



Зураг 1. “Уулбаян” нэртэй нүүрсний ордын байршлын зураг

2.4. Ордын нөөц

Уулбаянгийн ордын нүүрсний нөөцийг +420м-ийн үнэмлэхүй түвшин хүртэл буюу газрын гадаргаас 400м хүртэл гүнд, жишгийн үзүүлэлтийн шаардлагыг хангаж байгаа нүүрсний давхраасуудын нийт нөөцийг тооцоолон гаргалаа. Нүүрсний нөөцийг тооцоолохдоо 2021-2022 онд өрөмдсөн бүх цооногийн зүсэлт, каротажийн хэмжилтийн тайлал, кернийн дээжийн лабораторийн шинжилгээний үр дүнг бүрэн ашиглалаа.

Нүүрсний нөөцийг хэсэг бүрээр, нөөц тооцсон үнэмлэхүй төвшнөөр, нөөцийн зэрэгээр ялган үзүүлээ.

“Ричмайнинг” ХХК хайгуулын ажлыг 2021-2022 онуудад өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж, хайгуулын ажлын үр дүнгийн тайланг 2024 оны 04-р сарын 11-ний өдрийн ЭМБЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн ордын нийт нөөцийг боломжтой (С) зэрэглэлээр цэвэр нүүрсийг 3,433,838.69 тн, чулууны үетэй нүүрсийг 3,474,455.46 тн нүүрсийг Улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.

Хүснэгт 3. Нөөцийн нэгдсэн хүснэгт

Нөөцийн зэрэглэл, нүүрсний төрөл		БАРУУН ХЭСЭГ		ТӨВИЙН ХЭСЭГ		ЗҮҮН ХЭСЭГ		Нийт геологийн нөөц	
		/мян.тн/		/мян.тн/		/мян.тн/		/мян.тн/	
		Нүүрс	Чулууны үетэй нүүрс	Нүүрс	Чулууны үетэй нүүрс	Нүүрс	Чулууны үетэй нүүрс	Нүүрс	Чулууны үетэй нүүрс
С	Исэлдсэн	80.63	81.70					80.63	81.70
	Нүүрс	3,353.20	3,392.76					3353.20	3392.76
Боломжтой (С)		3,433.84	3,474.46					3,433.84	3,474.46

2.5. Хүчин чадал

Уулбаян нүүрсний уурхай нь жилд 400.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтайгаар төлөвлөөө. Уурхайн ашиглалтын нийт хугацаа 3 жил болно.

Хүснэгт 4. Хүчин чадал

Бүтээгдэхүүн	1 дэх жил	2 дах жил	3 дах жил	Нийт
Хөрс тэсэлгээгүй, м3	2,691,939.0	459,500.0	-	3,151,439.0
Хөрс тэсэрсэн, м3	3,519,498.0	6,128,995.0	7,527,867.0	17,176,360.0
Хөрс, м3	6,211,437.0	6,588,495.0	7,527,867.0	20,327,799.0
Нүүрс, м3	242,424.2	242,424.2	289,212.1	774,060.6
Нүүрс, тн	400,000.0	400,000.0	477,200.0	1,277,200.0
Нийт уулын цул, м3	6,453,861.2	6,830,919.2	7,817,079.1	21,101,859.6
Хөрс хуулалтын коэф, м3/тн	15.5	16.5	15.8	15.9
Нүүрсний ангилал, тн				
1/3 коксжих нүүрс	99,921.1	99,921.1	116,707.8	316,550.0
Дэгдэмхий бодис их хийн нүүрс	149,881.1	149,881.1	175,061.2	474,823.5
Бохирдолтой нүүрс	99,127.2	99,127.2	125,780.6	324,035.0
Эрчим хүчний цэвэр нүүрс	27,755.7	27,755.7	32,418.7	87,930.2
Эрчим хүчний бохирдолтой нүүрс)	23,314.8	23,314.8	27,231.7	73,861.4
НИЙТ НҮҮРС	400,000.0	400,000.0	477,200.0	1,277,200.0

2.6. Хөрсний овоолго

Ордын уул-геологийн нөхцөл, уурхайн хэтийн төлөв, ил уурхайн хүрээний гадна болон гүндээ үлдэж байгаа нөөц, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харгалзан үзэж уурхайд авто тээвэртэй, хөрсний гадаад овоолготой ашиглалтын системийг сонгон авсан.

Ашиглалтын нийт хугацаанд уурхайн хөрсний 0.22%-ийг шимт болон шимэрхэг хөрсний хэмжээ эзэлж байгаа бөгөөд үлдэгдэл 99.78%-ийг үндсэн хөрс эзэлж байна. Уурхайгаас гарах нийт хөрсийг утгуурт ачигч, экскаватораар ухаж ачин, автотээврээр тээвэрлэж шимт болон үндсэн хөрсний гадаад овоолгод байршуулах бөгөөд овоолгын хажуугийн тогтворжилтын өнцөг нь чулуулгийн физик-механикийн шинж чанараас хамааран 36-47° байна. Овоолго нь бульдозерын захилах хэлбэрийн гадаад овоолго байна.

Хөрсний овоолгын талбайн сонголтыг захиалагч байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр ордын хайгуулын ажлын үед өрөмдөгдсөн цооногуудаар нүүрсний үр ашигтай нөөцийн давхраас байхгүй гэдэг нь нотлогдсон талбайг сонгосон бөгөөд тээврийн зайг ашиглалтын жил тус бүрдээ жигд тогтмол байх, мөн уурхайн бүх нөөцийг олборлох үеийн ил уурхайн эцсийн хүрээ, түүний нурлын бүсийн гадна байрлахаар тооцоолсон болно.

2.7. Нүүрсний овоолго

Уурхайгаас олборлосон нүүрсийг нүүрсний түр хадгалах талбайд хурааж, түүнээсээ ахин борлуулалтын гадаад тээвэрт ачилт хийнэ. Нүүрс ачилтыг XCMG фирмийн 3м³ утгуурын багтаамжтай ZN50GN дугуйт ачигчаар ачина. Уурхайн 300,000-400,000 тн нүүрс агуулах хүчин чадал бүхий нүүрс хадгалах талбай байгуулна.

2.8. Технологийн сонголт

Төслийн ТЭЗҮ-д Уулбаян ордын уул техникийн нөхцөлд үндэслэн тээвэртэй ашиглалтын систем хэрэглэх боломжтой гэж үзэн гадаад болон дотоод овоолготой тээвэртэй ашиглалтын системийг сонгосон байна.

Хүснэгт 5. Ил уурхайн технологи

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	• Шимт хөрс хуулалт
		• Өрөмдлөг тэсэлгээ
		• Ухаж ачих
		• Тээвэрлэх
		• Овоолох
	Олборлолт	• Ухаж ачих
		• Тээвэрлэх
		• Овоолох

2.9. Шимт хөрс хуулалтын төлөвлөлт

Ордын ашиглалтын явцад уурхайн үйл ажиллагаанд өртөх уурхайн олборлолтын талбай овоолгын доод хэсэг, барилга байгууламж, замын өнгөн хэсгийн шимт хөрсийг уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө Монгол улсад дагаж мөрддөг шаардлага стандартын дагуу элс элсэнцэр зэрэг ургамал ургах боломжтой шимэрхэг хөрсийг 0.1 м хүртэл зузаантайгаар урьдчилан хуулна.

Шимт хөрс хуулах ажилд бульдозер ашиглах бөгөөд бульдозерын хуулсан хөрсийг утгуурт ачигчаар ачиж автосамосвалаар тээвэрлэн уурхайн хөрсний овоолгын ард байрлах шимт хөрсний овоолгод байршуулна. Ингэж хуулж бэлтгэсэн шимт хөрс нь орд ашиглалтын явцад болон ордыг ашиглаж дууссаны дараах нөхөн сэргээлтийн ажилд ашиглагдах юм.

Шимт хөрсний овоолгын өндөр нь 4 м байх бөгөөд хажуугийн өнцөг нь 25-30 градус байна. Уурхайн ашиглалтын хугацаанд нийт 430,258.0 мян.м³ шимт хөрс хуулна.

Хүснэгт 6. Ашиглалтын жилд уурхайгаас хуулах шимт хөрсний хэмжээ

Байршил	Эвдэгдэх газрын хэмжээ, м2	Шимт хөрс хуулах зузаан,м	Хуулах шимт хөрсний хэмжээ
Уурхай-1	223,887.00	0.3	67,166.10
Уурхай-2	91,835.00	0.3	27,550.50
Хөрсний овоолго	628,508.50	0.3	188,552.55
Нүүрсний агуулах	148,926.90	0.3	44,678.07
Уурхайн тосгон	22,500.00	0.3	6,750.00
Зам талбай	271,785.93	0.3	81,535.78
ШТС	9,750.00	0.3	2,925.00
Байршил	Эвдэгдэх газрын хэмжээ, м2	Шимт хөрс хуулах зузаан,м	Хуулах шимт хөрсний хэмжээ
Засварын талбай	37,000.00	0.3	11,100.00
Нийт	1,434,193.33	0.3	430,258.00

2.10.Техник, тоног төхөөрөмж

Ил уурхайн ашиглалтын системийн технологийн үе шатуудад 21 төрлийн техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглана.

2.11.Усан хангамжийн эх үүсвэр

Уурхайн усны хэрэглээг хангах зорилгоор тусгай зөвшөөрлийн талбайн урд шинээр худаг гаргана.

Мөн тусгай зөвшөөрлийн талбайн зэргэлдээ орших “Сорговь” нүүрсний уурхайн 2013 онд усан хангамжийн эх үүсвэрийн ундаргыг тогтоох зорилгоор “Эрдэнэ Дриллинг” ХХК-аар талбайн зүүн урагш ил уурхайгаас 8 км-ийн зайд гидрогеологийн усны хайгуулын ажлыг хийлгэсэн байна. Энэхүү цооногоос ахуйн болон тоос дарах зорилгоор ус ашиглаж байгаа бөгөөд шаардлагатай тохиолдолд харилцан тохиролцон тус худгаас усны хэрэглээг хэрэглэж болно.

Ус хэрэглээ:

Ил уурхайн ашиглалтын үеийн усны хэрэглээ нь унд-ахуйн ба технологийн ус хэрэглээ гэсэн 2 хэсэгт хуваагдана.

Нийт ус хэрэглээ:

Ил уурхайн ашиглалтын үеийн нийт ус хэрэглээ нь:
 $Q=Q_1+Q_2+Q_3=30,0+142,4+48,0=220,4 \text{ м}^3/\text{хон}=9,18 \text{ м}^3/\text{цаг}=2,55 \text{ л/с}$

Үүнд:

Q – Нийт ус хэрэглээ м³/хон

Q_1 – Унд ахуйн ус хэрэглээ - $m^3/хон$ Q_2 – Зам талбайн усалгаа -

$m^3/хон$ Q_3 – Ногоон байгууламжийн усалгаа - $m^3/хон$

Уурхайн усны хэрэглээг хангах зориулалтаар гаргасан гүний худгийн ундрага нь 5,0 л/с байгаа нь усны хэрэглээг хангаж байна.

Хүснэгт 7. Төслийн нийт усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Нийт ашиглалтын жилд
1	Унд, ахуйн усны хэрэгцээ	m^3	3,247.0
2	Зам талбайн усалгаа	m^3	61,401.6
Нийт усны хэрэгцээ		m^3	64,648.6

2.12. Ил уурхайн хэмжээс, процесс

- ✓ Ил уурхайн үйл ажиллагаа нь шимт хөрсийг түрж хуулах-овоолох, өгөршсөн хөрсний үеийг экскаватороор хуулж автосамосвалаар тээвэрлэн хөрсний овоолгод овоолсны дараагаар барилгын чулуу буюу дацит чулуулагт өрөмдлөг-тэсэлгээ хийж гүйцэтгэнэ.
- ✓ Тэслэгдсэн чулуулгийг ухаж ачин тээвэрлэн бутлуурын хажууд түр овоолгод овоолох бөгөөд бутлуурлуу чулуулгийг утгуурт ачигчаар хийнэ.
- ✓ Барилгын чулуу тээвэрлэлт. Ил уурхайгаас олборлож боловсруулсан барилгын чулууг худалдан авагчид Мандах суман дахь “Рич майнинг” ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэрт нийлүүлнэ.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүй: Дорноговь аймаг нь Монгол улсын хамгийн зүүн урд хэсэгт орших бөгөөд урд талаараа БНХАУ-тай, баруун талаараа Өмнөговь, баруун хойд хэсгээр Дундговь, Хойд талаараа Хэнтий, зүүн талаараа Сүхбаатар аймгуудтай тус тус хиллэн оршино.

Цаг агаар: Хөвсгөл, Мандах сумдын нутаг дэвсгэр нь уур амьсгалын хувьд манай орны бүх нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд хамаарагдах бөгөөд хавар, намар нь богинохон, өвөл, зуны улирал нь урт үргэлжилдэг, халуун, хүйтний хэлбэлзэл ихтэй байдаг. Жилийн аль ч улиралд баруун, баруун хойт зүгийн салхи зонхилж дунджаар 5-12м/с-ийн хурдтайгаар салхилдаг. Салхины сарын хэлбэлзэл нь 4, 5- р сар ба 6-р сарын эхэнд салхилалт хамгийн их, зарим үед шороон шуурга болж салхины хүч 35м/с хүрч хүн, малын амьдралд хүндрэл учруулдаг. Харин 6-р сарын сүүлээс 9-р сар хүртэл харьцангуй тогтуун 4-9м/с хурдтай болдог.

Жилд дунджаар 60-120мм хур тунадас унах ба хамгийн их хүйтэн нь 1-р сард -30⁰-35⁰С, хамгийн дулаан нь 7, 8-р сард дунджаар 30⁰-35⁰С дулаан болдог бөгөөд 2002 оны 7-р сард Монгол улсын хэмжээнд Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт хамгийн их халуун буюу 420С хүрч байсан. Өвлийн цагт цас бага ордог учир уулын ар өвөр, ар бэл, ам хөндий сайр талаар цасан бүрхүүл бага тогтоно. Энэ бүс нутагт геологийн хээрийн үйлдвэрлэлийн ажил явуулахад 6-10-р сар хүртэлх хугацаанд цаг агаарын хувьд тохиромжтой байдаг.

Усан орчин: Ус зүйн хувьд судалгаа хийгдсэн талбай нь Говийн их мужид хамаарагддаг тул задгай гол, горхи байхгүй бөгөөд оршин суугчид нь хүнсний болоод ахуйн хэрэгцээндээ дунджаар 2-8м гүнтэй худгийн усыг хэрэглэдэг. Малчид нь малаа тухайн жилийн хур тунадаснаас шалтгаалан тэжээгддэг ширгэдэг нуураас услах бөгөөд энэхүү нуур нь хур бороогүй гантай жилдээ хуурай нуурын шалыг үүсгэдэг юм. Судалгаа хийсэн талбайн ойр орчимд 15-30км-ын хэмжээнд гүний ба гар худаг тэмдэглэгдсэн. Үүнд: Айл баянгийн худаг Өлзийтийн худаг, Цагаан цавын гүний худаг байдаг. Ус нь цэнгэг, хүн малын ундны усанд тохиромжтой.

Хөрс, ургамал: Судалгааны талбай нь ботаник-газарзүйн мужлалаар говийн цөлөрхөг мужид багтана. Энд говийн хайргархаг элс, дайргархаг-элсэрхэг хөрс тархсан байх бөгөөд энэхүү хөрс нь ялзмаг багатай чийг хадгалалт муутай байдаг. Ус чийг багатай хуурай салхи ихтэй байдаг учир ургамалын бүрхэвч тачир сийрэг байдаг. Судалгааны талбайд дээрхи хөрс, нөхцөлд зохицсон ус чийг бага шаарддаг халуунд тэсвэртэй бутлаг, дэрслэг ургамал ургана. Энд хазаар өвс, чихэр өвс, цулхир, гоёо, таана, хөмөл, хулангийн ундаа, харгана, бударгана, шаваг, загсгал, тоорой, заг, хайлаас, сухай зэрэг ургамлууд ургана. Хөмөл, таана зэрэг сонгинолог ургана. Мөн, загсгал, чихэр өвс, цульхир зэрэг эмийн ургамлыг эмчилгээнд ашигладаг. Элсэн манхануудад хар суль, цульхир ихээр ургадаг бөгөөд хүмүүс түүж авч хүнсэндээ ашигладаг. Амьтны аймаг:

Ан амьтны аймгийн хувьд нэн баялаг бөгөөд туурайтнаас аргаль, хулан, цагаан зээр, хар сүүлт ховроор янгир, махчин амьтдаас чоно, шилүүс, үнэг, хярс, мануул, өмхий хүрэн, дорго, жигүүртнээс тас, бүргэд, сар, элээ, хэрээ, тоодог, тогоруу, харцага, болжмор, тагтаа, ногтруу, хулан жороо, өвөөлж, хэвлээр явагчдаас могой, гүрвэл, мэрэгчдээс бозлог, алаг даага, оготно зэрэг амьтадтай. Түүхт дурсгалт газар болон олдвор: Судалгаа явуулсан Дорноговь аймгийн Хөвсгөл, Мандах сумдын нутаг нь хүн төрөлхтөний өлгий нутаг болохыг илэрхийлэх боловч манай геологи хайгуул хийсэн судалгааны талбайн эргэн тойронд 50 км тойрогт түүх соёлын дурсгалт газар байдаггүй юм.

Амьтан: Энд говь цөлийн амьтад болох хулан, аргаль, янгир, хар сүүлт зэрэг туурайтан, махчин амьтдаас чоно, шилүүс, хярс, үнэг, өмхий хүрэн, мануул, жигүүртнээс бүргэд, тас, шонхор, харцага, элээ, ногтруу, тагтаа, болжмор, хулан жороо, хэвлээр явагчдаас олон зүйл гүрвэл, могой, мэрэгчдээс туулай, алаг даага, чичүүл, бозлог, шавьж идэштнээс зараа, шавьжаас хэдэн төрлийн аалз, арваалж, ямаан ууц, байх ба эдгээр амьтдаас нэн ховордсон, устаж алга болохын даваан дээр байгаа төрөл, зүйлүүдийг агнах, устгахыг хориглож дархан цаазтай болгожээ.

Нийгэм эдийн засгийн үзүүлэлт: Судалгааны талбайд төв суурин газар байхгүй, харин гадна талын Хөвсгөл, Мандах сумдын төв нь талбайн захаас 75-110 км зайтай оршиж Улаанбаатар хотоос 650км зайтай байрлах бөгөөд сумын төвүүд нь хүн эмнэлэг, мал эмнэлэг, эмийн сан, соёлын төв, харилцаа холбооноос Мобиком, Юнител, Скайтель зэрэг үүрэн холбооноос гадна Цахилгаан холбооны утас хэрэглэдэг, 10-н жилийн сургууль, дэлгүүр, банк, Хөвсгөл сум нь төвийн эрчим хүчний сүлжээнд 10 киловатийн шугамаар холбогдсон 24 цагийн цахилгаан ашигладаг. Харин тус ордоос хойш 140 км зайтай орших Зүүнбаян нь төвийн эрчим хүчний 110 киловатийн шугамаар хобогдсон байдаг. Зам харилцааны хувьд Улаанбаатар-Сайншанд-Замын Үүдийн ба УлаанбаатарСайншанд-Зүүнбаянгийн чиглэлийн төмөр замууд голлох үүргийг гүйцэтгэхээс гадна сум, аймгийн төвүүдийг холбосон шороон замуудтай. Мөн хээрийн үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой хээрийн жижиг замуудтай. Шинээр баригдахаар төлөвлөж буй Тавантолгойн нүүрсний орд Зүүнбаян хоёрын хооронд тамигдах төмөр замаас 30 км зайтай байна. Талбайн хэмжээнд хүн амын суурьшил харьцангуй сийрэг 1кв.км талбайд 0,1-0,2 хүн оршин суух бөгөөд хүн амын ихэнх нь халхчууд байдаг. Хүн амын цөөн хэсэг нь сум орон нутгийн төвд засаг захиргаа, үйлчилгээний байгууллагын ажилтан, ажилчид байх ба ихэнх нь мал аж ахуй эрхэлж түүнийхээ ашиг шим түүхий эдээр амьдрал ахуйгаа залгуулдаг. Айлбаянгийн чулуун нүүрсний орд нь Хангимандал хилийн боомтоос 145 км зайтай оршдог нь уг ордын нүүрсийг гадаад зах зээлд нийлүүлэх нь дөхөмтэй.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй үзүүлэлтүүдийг сонгон авсанаас хөрсний микроорганизм, амьтадын тархац нутаг, агаар орчинд тоос үүсгэх, хөрсний бохирдол, элэгдэл эвдрэл, ойр орчинд дуу чимээ ихсэх, газар ашиглалт, бэлчээр хомсдуулах, байгалийн түүхий эдийн нөөц багасах, үер ус орж голын сайр гольдрил өөрчлөгдөх, уурхайн үйл ажиллагаатай холбоотой осол аваарь гарах, байгалийн төрх байдал ландшафт өөрчлөгдөх зэрэг сөрөг нөлөөллүүд их, дунд, бага зэргийн эрчимтэйгээр нөлөөлж болзошгүй байна.

Харин байгалийн түүхий эрдэс баялагийг бүтээн байгуулалтын ажилд ашиглахад бэлэн болгох, нутгийн иргэдэд ажлын байр шинээр бий болгох зэргээр нийгэмд эерэг нөлөө үзүүлж болохоор байна.

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүд:

Хүснэгт 8. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Биосферийн элементүүд	Уулын үйлдвэрлэлийн үзүүлэх сөрөг нөлөөлөл	Гарч болзошгүй үр дагавар
Хөрс	Хөрс хуулалт Технологийн болон гадаад тээврийн зам хийх	• Газрын гадаргуугийн деформаци • Хөрсний элэгдэл, эвдрэлд орох • Газрын унаган төрх өөрчлөгдөх
Ус	Уурхайн усны хэрэглээг хянах Ил задгай талбайд ус тогтох	• Газрын доорх усны багасалт • Хөрсөнд ШТМ алдсанаас гүний усанд нөлөөлөх • Шатах тослох материалаар бохирдох
Агаар	Технологийн болон гадаад тээврийн зам	• Тоосжилт, • Агаарын бохирдол
Ургамал	Ургамлын бүрхэвч тоосжилтод дарагдах Уурхайн ухалтад	• Ургамлан нөмрөг устгах, • Ургамлын төрөл зүйл хомсдох - Бэлчээрийн талбай багасах
Амьтан		• Амьтдын амьдрах орон зай нь хумигдах • Байршил тархалт өөрчлөгдөх • Мал амьтан ашиглалтын талбай руу орох, карьерт унах

БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“РИЧ МАЙНИНГ” ХХК-ийн “Уулбаян” нэртэй нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө оршино.

“Уулбаян” нэртэй нүүрсний ордыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан.

Энэхүү БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

“Рич майнинг” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 102,110.0 мян.төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

“Уулбаян” нэртэй нүүрсний ордын үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсрууллаа.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Уулбаян” нэртэй нүүрсний ордын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНЕТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг, / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	Олборлолтын явцад карьерын ханыг ухах	Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх, тоос дарагч бодис ашиглах	Тээврийн хэрэгсэл	-	-	-	3,000,000	Тогтмол	MNS3113:1981 “Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага” MNS3384:1982
2	нураах, ачих, тээвэрлэх, овоолгод	Нүүрс түр хадгалах нүүрсний агуулахын нүүрсний овоолгод хаалт хийх, хаалтны бүрэн бүтэн байдлыг хангах	Талбайд	-	-	-	3,000,000	Жил бүр	“Агаар мандалАгаарын дээжлэлт шинжилгээ” MNS ISO4227-2002 “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS4585-2016
3	байршуулах зэрэг үйл ажиллагаан аас тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлөх	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яааралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах	Уурхайд	-	-	-	2,000,000	Тогтмол	“Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS5885-2008 “Агаарт байх бохирдуулах
4		Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох	-	-	-	-	1,200,000	Тогтмол	бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн

		(40 км/цагаас хэтрэхгүй байх), самбар тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засч сайжруулах							ерөнхий шаардлага” MNS6063-2010 “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ” MNS4990-2000 “ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”.
5		Ашиглагдаж буй машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийх	Тээврийн хэрэгсэл	-	-	-	1,000,000	Жил бүр	
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
1	Бүтээгдэхүүн олборлолтын хэмжээ нэмэгдсэн Үед хөрс хуулалт хийгдэх ба тухайн талбайн хөрсөн бүрхэвч гадаргаас зайлуулагдах	Олборлолт нэмэгдэх бүрт шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу байршуулж, хэлбэржүүлж хамгаалах	Шимт хөрсний овоолго	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	2026 онд	MNS3297-1991 “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”, MNS4919-2000 “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”, MNS4920-2000 “Эвдэрсэн газрын хажуугийн налуу.
2		Техникийн эвдрэл гэмтлийг зориулалтын талбай (засварын цех)-д байрлуулж засах	ШТМ	-	-	-	-	Тухай бүрт	
3		Засварын цех, ШТМ-ын агуулах, хуучин тос хадгалах цэг, ШТС зэргийн талбайг цементлэх, цаашид засч сайжруулж байх	ШТМ-ын талбай	-	-	-	5,000,000	2026 онд	

4		Уурхайгаас өртөө хүрэх гол замын сүлжээ, маршрутыг тогтоох, сайжруулсан хайрган хучилттай болгох, цаашид арчилж тордох	Талбай	-	-	-	-	2026 онд	Техникийн шаардлага” MNS5850-2008 “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
5		Ахуйн гаралтай шингэн хаягдлыг зориулалтын талбайд түр хадгалж биобэлдмэлээр тогтмол ариутгах, цаашид байгаль орчинд хальгүй зайлуулах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх	Шингэн хаягдал	-	-	-	-	Тогтмол	
Усан орчин									
1	-Бохир усыг ил задгай асгаснаас үүдэн орчны бохирдол үүсэх.	Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах	Ус ашиглах гэрээ	-	-	-	-	2026 онд	MNS0900:1992 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ; MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага; MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн усТухайн талбарт нь шинжилгээ хийх; MNS4432:1997 Ундны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох; MNS3934:1986
2		Усны бүх эх үүсвэрийг тоолууржуулах (ус шавхах насос, худаг г.м)	Гүний худаг	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	2026 онд	
3		Гүний худагт эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоолгож, хашаажуулан тэмдэгжүүлэх	Гүний худаг	-	-	-	3,000,000	2026 онд	
4		Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга	-	-	-	-	-	-	

		хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах							Ундны болон үйлдвэрийн усХимийн шинжилгээ хийх-дээж авах
Ургамлан нөмрөг									
1	Ил уурхайгаас хуулах хөрсийг автосамосвал- аар тээвэрлэх ба хүнд даацын машин механикийн нөлөөгөөр ургамлан нөмрөг талхлагдах, ургах чадвараа алдах	Барилга байгууламж, ажилчдын хотхоны гадна талбайд ногоон байгууламж бий болгох зорилгоор мод бут тарих, арчилж хамгаалах	Ногоон байгууламж	-	-	-	2,500,000	Жил бүр	Батлагдсан арга зүйн дагуу
Амьтны аймаг									
1	Хөрсөнд үүрлэдэг жигжиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд	Уурхайн эдэлбэр газраас бусад эрүүл талбайд газар ухаж, амьтны үүр сүйтгэхгүй байх	Амьтан	-	-	-	-	Тогтмол	Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй
2	биетүүдийн амьдрах орчин алдагдах, сүйтгэгдэх	Уурхайн ухаш руу мал амьтан орж эндэхээс сэргийлж эрсдэл үүсэх магадлалтай газруудаар хашаажуулат хийж сэргийлэх, жил бүр засаж сайжруулах		-	-	-	9,500,000	Жил бүр	
	Нийт зардал						30,200,000		

6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Тус уурхайн ашиглалтын системийн хувьд гадаад овоолготой, авто тээвэртэй ашиглалтын системээр олборлолтын ажил хийгдэх тул ашиглалтын 1-3 дах жилд уул техникийн нөхцөлөөс шалтгаалан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй бөгөөд ашиглалтын 4 дэх техникийн болон биологийн нөхөн сэргээлт, уурхайн хаалтыг хийж хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулан тусгасан ажлуудыг хэрэгжүүлж, 5 дах жилд уурхайн хаалтын дараах хяналт, мониторингийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

6.2. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил

Төсөл хэрэгжүүлэгч нь Тэрбум үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт ашиглалтын жилд 500 ш мод тарихаар төлөвлөсөн. Энэхүү ажлын хүрээнд төсөл хэрэгжих БОННУ-ийн 5 жилийн хугацаанд жил бүр 100 ш мод тарихаар төлөвлөлөө.

Хүснэгт 10. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө

№	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил	Модны төрөл	Тоо хэмжээ	Нийт зардал, Төг / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Модны суулгац худалдан авах	Улиас, хайлаас	100 ш	460,000	Нийт ашиглалтын хугацаанд
2	Цалин хөлс (Механикжуулагч, туслах ажилтан, технологийн ажилтан)			1,000,000	
3	Ногоон байгууламжийн арчилгаа тордолгоо, усалгаа, (Бусад зардал (хашаажуулалт, тээвэрлэлт бордоо))			2,000,000	
	Нийт			3,460,000	

6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх газрыг Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас санал авсны үндсэн дээр эвдэрсэн газрыг техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр санал, шийдвэрт хүрсэн.

Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутагтай хамтарч	Цаг агаар хүндэрсэн үед туруутан амьтны өвөл, хаврын бэлчээрт өвс тэжээл бэлтгэн тавьж өгөх	-	-	-	35,000,000	2026 онд	-Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэх гарын авлага, -БОНБНҮ-ий тухай хууль.
2	ажиллах, дүйцүүлэн хамгаалах ажил хийх санал орон нутгаас авах, хэрэгжүүлэх.	Тухайн бүс нутагт байрлах эвдрэлд орж, эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлыг сумын захиргаа, байгаль орчны газар санал тавьсан тохиолдолд хамтран хийх.	-	-	-			
Нийт зардал						35,000,000		

6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн эдэлбэр газар болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хийгдэхгүй болно.

6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвор илрээгүй. Уурхайн үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчдын аюулгүй ажиллагааны сургалтанд тогтмол хамруулах. Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж, хэвших	Тээврийн хэрэгсэл	-	-	2,000,000	Жил бүр	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги, -MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй -MNS 12.4. 005 – 1985: Хөдөлмөр хамгаалал.Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд.
2		Гал унтраах хэрэгсэл, галын сараа, элс зэргийг зохих газруудад байрлуулах, тэмдэг тэмдэглэгээ тавих	Уурхайн кемп	-	-	3,150,000	Жил бүр	
3		Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Уурхайн удирдлага	-	-	-	Жил бүр	
4		Аваар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Уурхайн удирдлага	-	-	1,000,000	Жил бүр	
5		БО хамгаалах сургалтыг зохион байгуулах	Уурхайн удирдлага	-	-	500,000	Жил бүр	
Нийт зардал						6,650,000		

6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /2026 он/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хатуу хог хаягдал	Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, зайлуулах, дахин ашиглах тогтолцоог нэвтрүүлэх, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан А-429/257 тоот тушаалын дагуу үүсэх хог хаягдлыг ангилан ялгах	Хог хаягдал	-	-	-	1,000,000	Жилд 1 удаа	-Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/, -MNS 5344:2011.
2		Хог хаягдлыг цуглуулах савыг стандартын шаардлага хангасан битүүмж сайтай хийх, ажилчдын байр, оффис, агуулах, ШТС зэрэг газарт байрлуулах, ариутгал, засварлаж байх	Хог хаягдлын сав	-	-	-	2,000,000	2026 онд	
3		Орон нутагтай хог хаягдлын гэрээ хийж төслийн талбайд үүссэн	Хог хаягдлын гэрээ	-	-	-	2,000,000	2026 онд	

		бүх хатуу хог хаягдлыг цуглуулах нэгдсэн цэгт хүргэх							
4		Хог хаягдал түр хадгалах цэгийн хог хаягдал сахлхиар хийсч тархахаас сэргийлэгдсэн, хөрсөнд нэвчихээргүй стандартын шаардлага хангахаар, ангилан ялгах цэгийг бий болгон жил бүр засаж сайжруулах	Хог хаягдал хадгалах цэг	-	-	-	500,000	2026 онд	
5		Хаягдал тос масло цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хийсэн гэрээний дагуу хаягдал тос маслыг нийлүүлэх		-	-	-	2,000,000	Тухай бүрт	
6	Аюултай хог хаягдал	Хаягдал тосыг хуримтлуулах сав байрлуулах, хаягдал дугуй, тос тосол болон төмрийн хаягдлыг ангилан цуглуулах цэгийг хашаажуулах, тэмдэг тэмдэглэгээ тавих, засаж сайжруулах	ШТМ хадгалах сав, поошик дүүрэхээр тээвэрлүүлэх.	-	-	-	3,500,000	Тухай бүрт	

7		Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаар авах	Аюултай хог хаягдал	-	-	-	-	2026 онд	
8		Шингэн хаягдлыг тусгай бодис хэрэглэн задлах		-	-	-	800,000	Улирал бүр	
9	Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хог хаягдлаас үүсэх бохирдлоос сэргийлэх үүднээс бага оврын цэвэрлэх байгууламж байгуулах	Шингэн хаягдал	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Төлөвлөх	
Нийт зардал							11,800,000		

6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Уулбаян” нэртэй нүүрсний ордыг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.

Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаарын орчин							
1	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ хийлгэх	-Ил уурхай орчмоос, -Бутлуурын хэсгээс.	Жилд 1 удаа	Агаарын сорьц дээж	1,000,000	Дорноговь аймгийн цаг уур орчны шинжилгээний харъяа лабораторит	-MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга,

Хөрсөн бүрхэвч							
1	Агрохимийн шинжилгээ: Хөрсний химийн үзүүлэлт (pH, EC _{2.5} dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃)	-Ил уурхай орчмоос, -Кемп орчмоос.	Жилд 2 удаа	-	350,000	Итгэмжлэгдсэн хөрсний шинжилгээний лаборатори	-MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох.
2	Хөрсний хүнд металлын шинжилгээ: (Cr, Cd, Pb, Ni, Co, Cu)	-Тээвэрлэлтийн замаас.	Жилд 2 удаа	-	350,000		
Усан орчин							
1	Усны химийн ерөнхий шинжилгээ: (pH, EC, TDS) нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ (CaCO ₃)	Унд ахуйн уснаас	Жилд 2 удаа	-	800,000	Усны итгэмжлэгдсэн лаборатори	-MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага, - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх, -MNS4432:1997 Ундны ус. Өнгийг тодорхойлох арга,
Ургамлан нөмрөг							

1	Ургамал устгах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, биомасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамал	Төсөл хэрэгжиж буй талбай болон түүний ойр орчим 4 цэгт	-	2,000,000	Жил бүр	ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах
Нийт зардал					4,500,000		

6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон Төсөв / 2026 он /	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 онд				
			6-р сар	7-р сар	8-р сар		
1	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны зардалд орсон		+		Уурхайн удирдлага	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх шаардлагатай.
2	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын нэг бүрийн хэрэгслээр бүрэн хангах	5,000,000					
3	Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	3,000,000					
4	Дотоод хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх	1,000,000					
5	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх аян, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	1,500,000					
6	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 101 дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх	Мэргэжлийн байгууллагатай тохиролцох					

7	Тусгай зөвшөөрөлтэй талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг хийлгэх	Мэргэжлийн байгууллагатай тохиролцох					
8	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээг шинэчлэн байгуулж, гэрээний дагуу хамтран ажиллах, шинэчлэх	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Уурхайн удирдлага	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан нягт хамтран ажиллах
Нийт зардал		10,500,000					

6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

"Рич майнинг" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 16. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Дорноговь аймаг	Орон нутгийн байгаль орчны газар	Тайлан хэлбэрээр, уурхайн талбайд очих.	БОМТ-ийн 2025 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ны өдрийн дотор	Уурхайд
БОУАӨЯ	БОУАӨЯ-ны ХБОБНУГ	Тайлан			БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т
Төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр	2026 оны БОМТ	12-р сарын 01-ны өдрийн дотор	-

2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

“Рич майнинг” ХХК-ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

2026 онд БОМТ-нд нийт **102,110,000** сая.төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 17. 2026 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2026 он /төгрөг/
1	Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	30,200,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
	Тэрбум модны төлөвлөгөө	3,460,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	35,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	11,800,000
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	6,650,000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	10,500,000
9	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4,500,000
Нийт дүн		102,110,000

ДҮГНЭЛТ

Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших “Рич майнинг” ХХК-ийн “Уулбаян” нэртэй нүүрсний ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу биелэлтийн тайланг боловсруулж дараах дүгнэлтэд хүрлээ.

“РИЧ МАЙНИНГ” ХХК-ийн 2026 оны БОМТ-ний биелэлтийн тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Уг төслийн явцад байгаль экологийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг мөрдлөг болгон ажиллаж, 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

“Уулбаян” нүүрсний ордын БОМТ-нд 2026 онд нийт **102,110,000** төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

“РИЧ МАЙНИНГ” ХХК нь БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014
7. Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших ДО-004А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Уулбаян” Нүүрснийордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ, 2021 он
8. Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших “Уулбаян” Нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2025 он
9. Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших “Уулбаян” Нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн БОМТ, 2025 он
10. <http://www.legalinfo.mn/>